



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 14, 8.1 дүгээр зүйлийн 6.1, Аудитын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аккурэйт Аудит” ХХК, “Найдвар Од Аудит” ХХК нарын аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс, “Кэй Пи Эм Жи Аудит” ХХК-ийн аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс, “Релаэнс Секюритиз Аудит” ХХК-ийн аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 2024 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс, “Эма Финанс Аудит” ХХК-ийн аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс, “Ниямазон Аудит” ХХК, “Оюу Эрдэм Аудит” ХХК нарын аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 2024 оны 02 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн гурван жилийн хугацаатайгаар тус тус сунгасугай.

2. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгагдсан хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Б.Болормаа/-т үүрэг болгосугай.

Б.ЖАВХЛАН

9763000136